

**ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, ДЭД ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**
(Жилийн эцсийн байдлаар)

2023.12.15

Дархан

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл								
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар: “Архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавих аймгийн дэд хөтөлбөр” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 46 дугаар тогтоол	Төсөл, хөтөлбөрийн зорилго: Архидалтаас үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.								
2	Санхүүжилтийн эх үүсвэр:	Улсын төсөв/зээл/ буцалтгүй тусламж: 1. Орон нутгийн төсөв; 2. Гадаад, дотоодын тусламж, дэмжлэг хандив; 3. бусад эх үүсвэр;								
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа: 2023-2027 он	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хөтөлбөрийг төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлж, биелэлтийг хагас, бүтэн жилээр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Засаг даргын Тамгын газарт тайлагнана. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хөтөлбөрийн биелэлтийг нэгтгэн дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Цагдаагийн газар, сумдын ИТХ, Засаг дарга								
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд:	Зорилт 1. Олон нийтэд архидалт, түүний хор уршгийг ойлгуулан таниулж соён гэгээрүүлнэ. Зорилт 2. Иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцлийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулна. Зорилт 3. Архинд донтох эмгэгтэй иргэнийг эмчлэн эрүүлжүүлнэ.								
5	Зардал	Төсөв(Нийт зардал)	шаардагдах							
		Үүнд:	Төсөв / он/		Гүйцэтгэл			Хувь		
		Багц 1	0	0	0	0	0	0	0	0
		Багц 2 (г.м)	0	0	0	0	0	0	0	0
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт: 1 дүгээр зорилтын хүрээнд: Олон нийтэд архидалт, түүний хор уршгийг ойлгуулан таниулж соён гэгээрүүлнэ.	Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг олон нийтэд таниулах чиглэлээр аймгийн ЗДТГ, ЦЕГ, Соёлын яамнаас зохион байгуулсан “ Намайг алгас ”, “ Анзаар ”, “ Нийгэм соёл, төлөвшлийн төлөө ”, “ Хамтаар амьдрах соёл ”, “ Хотын соёл ” зэрэг нөлөөллийн аянууд болон урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх бусад арга хэмжээг жилийн турш тасралтгүй явуулж ажиллалаа. Үүнд: -Монголын шог зураачдын "Шогч бийр" холбоо, Монголын Эмнести Интернэшнл байгууллагатай хамтран “Хүний эрх, эрх чөлөө” сэдэвт асуудал хөндсөн шог зургийн үзэсгэлэнг 2023 оны 04								

		<p>дүгээр сарын 10-16-ны өдрүүдэд аймгийн Музейд зохион байгуулсан. Уг үзэсгэлэнгийн үеэр нийт 120 гаруй шог зураг дэлгэгдсэнээс архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг сурталчлан таниулах 9 зургийг иргэд, олон нийтэд сурталчиллаа. Тус шог зургийн үзэсгэлэнг орон нутгийн телевизүүдээр сурталчлан нийт 487 иргэд олон нийтэд хүргэсэн..</p> <p>-2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр аймгийн Төв номын санд “Зурагдсан пянз” шинэ номын нээлтээр 30 гаруй шог зураг дэлгэгдсэнээс архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг сурталчлан таниулах 6 зургийг иргэд, олон нийтэд сурталчилсан.</p> <p>- Аймгийн Төв номын сантай хамтран “Архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах нь” сэдвээр 25 боть номоор үзэсгэлэн гаргаж сурталчилсан.</p> <p>- Шарын гол, Орхон, Хонгор сумдын Соёлын төвүүд сумын Цагдаагийн хэсэгтэйгээ хамтран ойр орчны аюулгүй байдлыг ханган ажиллах хуваарийн дагуу 2 удаа эргүүлд гарч ажилласан.</p> <p>- Соёл, урлагийн газар, Соёлын байгууллагууд “Цагаан сар”, “Үндэсний их баяр наадам”-ын өдрүүдэд хариуцлагатай жижүүрээр ажиллан архидан согтуурах, бэртэж гэмтэх аюулаас урьдчилан сэргийлж, хараа хяналт тавин ажилласан.</p> <p>- Тус аймгийн төрийн байгууллагуудад шинэ жилийн баяраа "АРХИГҮЙ ШИНЭ ЖИЛ" уриан дор тэмдэглэх уриалга гаргаж, Архи, согтууруулах ундааны хор хөнөөлийн тухай мэдээлэл бэлтгэн байгууллагын цахим хуудас, социал сувгаар таниулан сурталчилсан. Архи, согтууруулах ундааны хор хөнөөлийн тухай - Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар (mcs.gov.mn) Ингэснээр баярыг архидалт болгон хавтгайруулан тэмдэглэхээс сэргийлэх юм.</p>
	<p>2 дугаар зорилтын хүрээнд: Иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцлийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулна.</p>	<p>-Тус газраас ажлын байранд архидан согтуурахгүй байх, аливаа баяр ёслолыг архигүй тэмдэгл, архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулж ажиллах чиглэлийг соёлын байгууллагуудад хүргүүлж ажилласан.</p> <p>-Соёлын яамны Салбарын хяналтын газраас 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тус аймагт ажиллаж үйл ажиллагаа явуулж буй 32 караоке, 1 эвент танхим, 1 кинотеатр, 8 сүм хийд, ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн нийт 44 номын сан, Залуучууд театр, Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордны үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийж, 13 объектыг тандалт судалгаанд хамруулсан. Мөн үеэр архи, согтууруулах ундаа борлуулдаг, үйлчилгээ үзүүлдэг газруудад хуулийн хэрэгжилтийг сурталчлах, иргэдэд ээлтэй үйлчилгээ үзүүлэх хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулж ажиллах чиглэл өгсөн.</p>
	<p>3 дугаар зорилтын хүрээнд: Архинд донтох эмгэгтэй иргэнийг эмчлэн эрүүлжүүлнэ.</p>	<p>-Тус газарт архинд донтох эмгэгтэй албан хаагч байхгүй болно.</p>
7	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон ололттой тал: Дутагдалтай тал:</p>
8	<p>Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ</p>	<p>.....</p>

9	Төсөл, хөрөнгөний хөрөнгөний үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		99.3%	3	100%	98%	100%
10	Төсөл, хөрөнгөний хөрөнгөний үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ:%				
	%				

ХЯНАСАН:
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА



Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:
СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Б.ДОЛГОРМАА